

ЕРӨНХИЙ САЙД П.ГЭНДЭНГИЙН ЗӨВЛӨЛТӨД ХИЙСЭН 1934 ОНЫ АЙЛЧЛАЛ БА БАТЛАН ХАМГААЛАХ ХҮЧИЙГ ЗУЗААТГАХ ТАЛААР ХИЙСЭН АЛХАМУУД

Д.Дашдулам

Өгүүллийн товч утга: 1930-аад оны эхэн үеийн Монгол-Зөвлөлтийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэсэн ерөнхий сайд Гэндэнгийн ЗХУ-д хийсэн 1934 оны айлчлалын талаар тусгасан юм. Уг айлчлал нь хоёр улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Алс дорнодын харилцаанд Зөвлөлтийн байр суурийг бэхжүүлэхэд зохих нөлөөг үзүүлсэн юм. Гэндэн Н.В.Сталины уулзалтаар монголын батлан хамгаалах хүчийг зузаатгахад голлон анхаарсан байдаг.

Түлхүүр үг: Цэргийн довтолгоо, айлчлал, арми, лам нар, батлан хамгаалах хүч хувьсгалын эсэргүү, дотоодын яам

1930-аад оны дунд үе болж ирэхэд олон улсын байдал, тэр дундаа Алс дорнодод байдал түгшүүртэй болсон байлаа. Энэ бүс нутагт хүрээгээ тэлж нөлөөгөө тогтоон өргөжүүлэх гэсэн Зөвлөлт, Японы өрсөлдөөн ил тод өрнөх болсон хэдий ч 1930-аад оны эх болоход Японы тал давамгайлах болжээ. Үүний тодхон жишээ бол 1932 онд Японы засгийн газар Зөвлөлтийн талаас тавьсан “Харилцан үл довтолох гэрээ” байгуулах саналыг хүлээн авалгүй няцаасан явдал юм.

Үүний дараахнаас эхлэн Зөвлөлтийн дээд удирдлагууд Монголын асуудалд улам анхаарах болсон төдийгүй 1934 оноос Зөвлөлтийн засгийн газрын урилгаар БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд П.Гэндэн тэргүүтэй төлөөлөгчид албан ёсны айлчлал хийжээ.

Энэ айлчлалаар Монгол банкны өрийг хүчингүй болгон, Монгол-Зөвлөлтийн худалдааны үндсэн зарчмуудын тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан төдийгүй Монголын батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх талаар тодорхой ярилцсан байна.

Зөвлөлтийн тал Монголд тухайн үед байсан цэргийнхээ тоог 10000-аас 12000-д хүргэхийг шаардаж, зөвлөлтийн тал таван жилийн турш жил бүр 6 сая төгрөгийг зөвхөн армийн зардалд буцалтгүй тусламж маягаар өгч байхыг амалсан аж.

Мөн энэхүү айлчлалаар “Цэргийн довтолгооныг урьдчилан зайлуулах, түүнээс урьдчилан сэргийлэх хэрэгт бие биеэ бүх талаар харилцан дэмжих, ямар нэгэн гурав дахь этгээд ЗСБНХУ, БНМАУ-руу довтолбол бие биедээ тусламж

дэмжлэг өгнө”¹ гэсэн аман хэлэлцээрийг байгуулжээ. Уг хэлэлцээрийн цаад учир шалтгаан нь БНМАУ-ын газар нутаг дээр өөрсдийн улаан армийн цэргийг оруулах ажиллагааны эхний алхам байсан юм. Тийм ч учраас зөвлөлтийн тал энэхүү айлчлалын бэлтгэлийг хангуулахад онцгой анхаарсан нь харагддаг.

1934 оны X сарын 23-ны БХК(б)Н-ны Төв Хорооны Улс төрийн Товчооны хуралдаанаар Монголын төлөөлөгчдийг хэрхэн хүлээн авах болон хэлэлцээр явуулах комиссын бүрэлдхүүн, хэлэлцэх асуудлын талаар ярилцсан байдаг.

Уг хурлаас Монголын төлөөлөгчидтэй уулзан хэлэлцээр хийх комиссыг Ш.З.Элива (дарга нь) Б.С.Сокольников, Стомоняков нарын бүрэлдхүүнтэйгээр баталжээ.²

И.В.Сталин, П.Гэндэн нар Москвад нийтдээ дөрвөн удаа буюу 1932 оны XII сард, 1933 оны XII сард, 1934 оны XI сард, 1955 оны XII сард тус тус хүлээн авч уулзсан байна.

Миний бие энэхүү бэсрэгхэн өгүүлэлдээ Ерөнхий сайд П.Гэндэнгийн И.В.Сталинтай хийсэн сүүлийн хоёр удаагийн айлчлалын уулзалтын талаар өгүүлэхийг зорьсон юм. Эхний уулзалтуудыг бодвол сүүлийн 1934-1935 оны уулзалтууд нилээд зөрчилтэй, И.В.Сталинаас П.Гэндэнг дайрсан, шүүмжилсэн өнгө аястай болсон байдаг.

Эхний айлчлал буюу 1934 оны XI сард Москва хотноо болсон ба Монголын талаас П.Гэндэн, Р.Мэнд, О.Дашчирар, Х.Чойбалсан, Нанзад, Д.Яндаг, М.Ядамсүрэн, Ж. Самбуу нарын арав гаруй төлөөлөгчид оролцсон ба И.В.Сталинтай хийсэн уулзалт 1934 оны XI сарын 15-ны өдөр 3 цаг гаруй үргэлжилжээ. Уулзалтанд И.В.Сталинаас гадна Молотов, Ворошилов, Каганович, Жданов, Сокольников, Элилва нар оролцсон ба орчуулагчаар Ильин нар оролцсон байна. Ильин нь П.Гэндэнг Москвад түр зуур байх үед нь түүний нарийн бичгийн дарга, орчуулагчийн үүргийг давхар гүйцэтгэж байжээ.

Уулзалтын явцын талаарх тэмдэглэлээс үзэхэд лам нар сүм хийдийн талаар хатуу, ангич бодлогыг эрс хатуу эрчимжүүлэх, засгийн газар, УБХ-ын бүтэц болон ДХГ-ыг яам болгон өөрчлөх зэрэг олон асуудлыг хөндсөн байдаг.

Гэхдээ уулзалтын гол сэдэв нь П.Гэндэнгийн хэлсэнчлэн “БНМАУ-ын нам, засагт үндсэн аюул учруулж байгаа лам нарын тухай” асуудал байлаа. Магадгүй

¹ Монгол-Зөвлөлтийн харилцаа, I боть 362 дах тал

² МУУТА, х445, д-5, хн-72, 40 дэх тал

энэ нь П.Гэндэнгийн өөрийн санаа бус Зөвлөлтийн байр суурьт тохируулсан бага буурай орны удирдагчийн “зовлон” байсан билээ.

Тиймдээ ч Воршиловоос “Ардуудын дунд засгийн газар ба нам, лам нарын аль нь илүү нөлөөтэй байна” хэмээн асуухад нь: “Лам нар нь илүү байх аа...засаг захиргааны хувьд лам нар бидэнд дуулгавартай, харин ардуудын дунд бол лам нар биднээс илүү нөлөөтэй”³ хэмээн үнэн үг хэлсний төлөө И.В.Сталинаас хатуу зэмлэлийг хүртсэн байна.

И.В.Сталинаас: “Танайд улсын дотор улс байгаа байдалтай болжээ. Нэг засгийн газар нь Гэндэнгийн засгийн газар, нөгөө нь лам нарын. Гэхдээ лам нарын засгийн газар нь хүчтэй. ...Лам нар нь хүчтэй тул түүнийг аажмаар бүслэн авах хэрэгтэй болно”⁴ гэжээ. Хамгийн ноцтой нь лам нарыг шийтгэхдээ хувьсгалын эсэргүү хэмээх ерөнхий нэрийн зэмлэлээр бус, эх орноосоо урвасны төлөө шүүх хэрэгтэй... гэхдээ ийм практик нь одоохондоо хааяа нэг байж болно. Лам нар нь ихээхэн хүчтэй тул түүнийг аажмаар бүслэн авах хэрэгтэй” хэмээн зааварчилсан байдаг. Бодит байдал яг ийм дүр зургийн дагуу явагдсан байдаг бөгөөд 1937 он гэхэд сая л нэг хэрэгжих бололцоо бүрдсэн юм.

Уулзалтаар яригдсан бас нэг зүйл чухал бол Засгийн газар УБХ-ын бүтэц, бүрэлдхүүний талаар ярилцаж тохиролцсон байх ба П.Гэндэнгээс тавьсан Шүүх яамыг татан буулгах тухай саналыг эрс эсэргүүцжээ. И.В.Сталинаас: “Шүүх яамыг устгаж болохгүй, тэр нь байх нь чухал. Улсын аюулаас хамгаалах газрыг Дотоод явдлын яам болгон өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна”⁵ хэмээн зөвлөжээ. Гэсэн хэдий ч хожим 1936 оны II сарын 26-нд ДХГ-ыг ДХЯ болгон өөрчилсөн нь П.Гэндэнг И.В.Сталины заавар зөвлөлгөөг биелүүлдэггүй хэмээн буруутгах гол үндэслэлүүдийн нэг болсон юм.

Энэхүү уулзалтын төгсгөл үеэр Ерөнхий сайдын орлогчийн асуудал яригдсан байдаг. П.Гэндэнгээс хоёр орлогч хавсарч ажилладаг гэхийн хамт Г.Дэмидийг цэргийн шугамаар бэлтгэгдсэн тул бусад ажлын хувьд бэлтгэл дутагдалтай хэмээн “хов” хүргэсэн байдаг. Гэхдээ үүнийг нь нөхдүүд “Гэндэн-Дэмидийн харилцаа”-ны зөрчлөөс үүдэлтэй хэмээн ойлголт өгөхөөс сэргийлэх,

³ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг, (1920-1952) II 6, УБ 2005, 102 дахь тал

⁴ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг, (1920-1952) II 6, УБ 2005, 103 дахь тал

⁵ Мөн тэнд, 108 дахь тал

“Дэмид бид хоёрын зөрчил (урьд нь байсан, одоо байхгүй) байснаас би итгэж ярьж байгаа биш, бодит байдлыг л ярьж байгаа хэрэг”⁶ гэсэн байдаг.

В.М.Молотовоос нэгдүгээр орлогчоороо хэнийг тавихаар төлөвлөж байгааг асуухад, П.Гэндэнгээс: “Энэ ажилд н.Чойбалсан Дэмидийг бодвол илүү бэлтгэлтэй хэмээн би үзэж байна” хэмээн хариулсан байдаг. П.Гэндэнгийн дээрх хариулт ихээхэн сонирхол татах бөгөөд албан бус уулзалтын үеэр ерөнхий сайдын орлогчийн асуудал болон ямар бүтэцтэйгээр ажиллах болон орлогчоор нь Х.Чойбалсан, Г.Дэмидийн аль нь байж болох талаар ярилцсан бололтой. Хэрэв энэ талаар урьд нь ярилцаагүй байсан бол П.Гэндэнгээс В.М.Молотовт шуудхан “Энэ ажилд н.Чойбалсан Дэмидийг бодвол илүү бэлтгэлтэй хэмээн би үзэж байна” гэмээн эрс тод нэр зааж хэлэхгүй байсан болов уу.

Үнэндээ бол Г.Дэмид нь Х.Чойбалсанг бодвол Монголд нам, төр, цэргийнхэний дунд илүү нөлөөтэй хэдий ч Ерөнхий сайд П.Гэндэнтэй төдийлөн сайнгүй харилцаатай байжээ. Ялангуяа тэдний харилцаа хүйтрэхэд, “зүүнтний” засаглалын төгсгөл үе нам, төрийн удирдагчдын дунд аль хэдийн бий болсон үзэл бодлын зөрүүнээс үүдэлтэй бүлэглэлүүдийн зөрчил улам бүр сэдрээж байсан гэлтэй, нөгөө талаар Г.Дэмидийн нам, төр, цэргийн удирдах бүрэлдхүүн болон жирийн ард иргэдийн дотор улам бүр нэр алдар нь өсөн дээшилж байгаад П.Гэндэнгээс “болгоомжлох” нь аргагүй байсан бизээ.

Ерөнхий сайд П.Гэндэнгийн хувьд хожмын урхагтай үйлийг гардан хийх Х.Чойбалсанг хэмжээлшгүй их эрх мэдлийн оргилд хүрэх замыг засаж буйгаа ч мэдээгүй буй заа. Гагцхүү тухайн үед өрсөлдөгч Г.Дэмидийн эрх мэдлийг багахан боловч хязгаарлаж чадсандаа л олзуурхсан болов уу.

Уг уулзалтан дээр Сталин, Молотов нараас уг саналыг хэрхэн үзэж буйг Х.Чойбалсангаас асуухад “Би бол мал аж ахуйн асуудлыг илүү сонирхдог”⁸ хэмээн “даруухан” заганаасан байдаг.

Үүнийг сонссон Сталин “Сайд нарын зөвлөлийн орлогчийн албан тушаалд байхдаа та мал аж ахуйгаас хөндийрөхгүй. Шинэ үүргээрээ та мал аж ахуйг

⁶ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг, (1920-1952) II 6, УБ 2005, 108 дах тал

⁷ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг, (1920-1952) II 6, УБ 2005, 103 дах тал

⁸ Мөн тэнд 109 дэх тал

урьдын адил удирдах болно" хэмээн хэлсэн нь Х.Чойбалсан Ерөнхий сайдын орлогчид хэрэг дээрээ томилсон хэрэг байв.⁹

Энэ удаагийн уулзалт эхнээсээ эцсээ хүртэл П.Гэндэнг довтолсон шинжтэйгээр гурван цаг гаран үргэлжилсэн байдаг бөгөөд гол шийдвэрлэсэн зүйл нь Х.Чойбалсанг Ерөнхий сайдын I (нэгдүгээр) орлогчоор томилуулсан явдал байлаа.

БНМАУ нь 1930-аад оны дунд үе гэхэд туурга тусгаар тогтносон улс мэт гадаад улсуудад харагддаг боловч үнэндээ дотооддоо асуудлаа шийдвэрлэх ч эрхгүй бүхий л зүйлд ЗХУ-аас хараат, дагуул орон байсан юм.

Abstract: This article narrates about the visit by Prime Minister P. Genden to Soviet Union made in 1934, which was an important period in relations between Mongolia and the Soviet Union. At the meeting between P. Genden and I. V. Stalin the main stress was made on strengthening Mongolia's defencive capabilities.

⁹ О.Ичинноров, П.Гэндэн, И.В.Сталин нарын харилцааны асуудалд, "Үнэн" сонин 1990.09.13. №216 (17746)